



"ДАРХАН ХҮНС" ХК  
SINCE 1971

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

### ХУРЛЫН ТОВ

|                    |                                          |
|--------------------|------------------------------------------|
| Хурал болсон газар | Дархан-Хүнс ХК-ийн хурлын танхим         |
| Он сар өдөр        | 2026 оны 04-р сарын 13-ний өдөр хуралдав |
| Хурлын цаг         | 14:00-17:00 цагт боллоо                  |

### ХУРЛЫН ИРЦ

|                                       |                                                       |
|---------------------------------------|-------------------------------------------------------|
| Хурлын дарга                          | Сүүний цехийн мастер, ҮЭ-н хорооны дарга Н.Ичинхорлоо |
| Хурлын ирц                            | 71,6%                                                 |
| Хуралд оролцсон<br>хувьцаа эзэмшигчид | 7 хувьцаа эзэмшигчид                                  |



### ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

1. Компаний 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийгн хэлэлцэж батлах
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах
3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн дэргэдэх аудит болон хороодыг сонгох

Тооллогын комиссын дарга Д.Мөнхцэцэг:

### "ДАРХАН ХҮНС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц болон  
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Дархан Хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 442.679 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 617,718 ширхэг энгийн хувьцааны 71,664% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дэх заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 71,664% -ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

**Хурлын дарга Н.Ичинхорлоо:** Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргье. Дархан Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнээр тул хурал боломжтой боллоо. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлын дарга хурлыг нээх
- Компаний 2025 оны санхүү болон үйл ажиллагааны тухай, тайлан тэнцлийн дүнгийн тухай.
- Хөндлөнгийн Аудит “ЦЭСБ Аудит” ХХК-наас Дархан Хүнс ХК-ний 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт
- “Дархан Хүнс” ХК ний 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлт
- 2026 оны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- Компаний хяналтын зөвлөлийг сонгох
- Асуулт хариулт
- Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
- Хурлын дарга хурлыг хаах гэсэн дараалалтай явна.

Компанийн танилцуулгыг гүйцэтгэх захирал Г.Нямдалай танилцуулна.

**Г.Нямдалай:** Сайн байцгаана уу. Та бүхэнд 2025 онд хийж гүйцэтгэсэн томоохон гол ажиллуудаа танилцуулсан. 2025 онд ТУЗ-ийн даргаар Д.Бат-Эрдэнэ, гүйцэтгэх захирлаар миний бие ажилласан. Энэ хугацаандаа томоохон хөрөнгө оруулалт хийж тоног төхөөрөмжийг шинэчилэл хийсэн.

| Үзүүлэлт                         | 2024 он       |               |       | 2025 он       |               |       | Өөрчлөлт ( + - ) |       |
|----------------------------------|---------------|---------------|-------|---------------|---------------|-------|------------------|-------|
|                                  | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл     | Хувь  | Төлөвлөгөө    | Гүйцэтгэл     | Хувь  | Гүйцэтгэл        | Хувь  |
| Борлуулалтын орлого (НӨАТ-тай)   | 6,673,427,850 | 5,650,297,500 | 84.7% | 6,259,817,051 | 6,052,783,171 | 96.7% | 402,485,671      | 12.0% |
| Борлуулалтын хорогдол ба буцаалт | 124,231,976   | 115,966,227   | 2.1%  | 75,131,402    | 188,917,819   | 3.1%  | 72,951,592       | 1.1%  |
| Борлуулсан бүтээгдэхүүний Өртөг  | 3,943,485,455 | 3,321,805,396 | 58.8% | 3,963,762,223 | 3,893,529,712 | 64.3% | 571,724,316      | 5.5%  |

Дархан-Уул аймгийн шилдэг аж ахуй нэгж “Шинэ инвази” нэвтрүүлсэн хамт олон



Хөрөнгө оруулалт




LBC SE-9 Series





|                       |                                           |
|-----------------------|-------------------------------------------|
| Олон хошуутай хэв     | Нэг болон 2 өнгийн бүтээгдэхүүн, чимэглэл |
|                       |                                           |
| Эргэдэг хэв           | Нэг болон 2 өнгийн бүтээгдэхүүн, чимэглэл |
|                       |                                           |
| Утсаар таслах аппарат | Нэг болон 2 өнгийн бүтээгдэхүүн           |
|                       |                                           |





### ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ, ӨРГӨТГӨЛ



2025 онд "ЦЭСБ АУДИТ" ХХК хараат бус аудитын ажлыг хийсэн.

"Дархан Хүнс" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л

материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн баталсан журам, заавар, аргачлалын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна. гэж дүгнэсэн.

**Хурлын дарга: Н.Ичинхорлоо:** 2025 оны ерөнхий тайлангаа тавьсан гүйцэтгэх захиралдаа баярлалаа.

**Одоо 2025 оны санхүүгийн тайланг ерөнхий нягтлан бодогч танилцуулна.**

**Ерөнхий нягтлан Х.Болорцэцэг:** Аудитын компаниас тодорхой хэмжээний зөвлөмжүүдийг өгсөн. Зөвлөмжийн дагуу компанийн гүйцэтгэх удирдлага төлөвлөгөө гаргаж түүнийгээ ТУЗ руу илгээж ТУЗ-өөс зөвшөөрсний дагуу дараах зөвлөмжийн дагуу төлөвлөгөөтэй ажиллаж ирсэн. 2025 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон компанийн санхүүгийн тайланд "ЦЭСБ АУДИТ" ХХК ажиллан аудит хийж гүйцэтгэсэн. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын сангийн яам, Санхүүгийн зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж тайлбарыг өгсөн байгаа.

**Хурлын дарга:** 2026 оны төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Нямдалай танилцуулна.

**Г.Нямдалай:** 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг товч танилцуулья. Бид орлогоо нэмэгдүүлэх, зардлаа хэмнэе гэсэн зорилготойгоор бид ажиллаж байна. Мөн ажилчдын ур чадварыг сайжруулах маркетингийн оновчтой бодлогуудыг хэрэгжүүлэх гээд 19 зорилгын хүрээнд 61 дэд ажлуудыг төлөвлөн ажиллаж эхэлсэн. Эдийн засгийн хямралын нөлөөгөөр зарим төлөвлөсөн ажлууд хасагдах мөнгөтэй холбоотой томоохон арга хэмжээний ажлууд хасагдах байдалтай явж байгаа. Гэхдээ бид алдагдалыг бууруулахын төлөө ажиллаж байна. үүнээс санхүү болон үйл ажиллагааны зардлыг нэлээд сайн танаж ажиллах шаардлагатай байгаа.

**Хурлын дарга:** Борлуулалт, цэвэр ашгийн хэмжээнд бүх байгууллага дээр яригдаж байгаа. Ажиллагсадынхаа ажлын байрыг авч үлдэх эсэх тодорхой бус байдал ихээхэн үүсэж байна.

**Ерөнхий нягтлан:** Өмнөх гаргаж байсан төсөв, түлшний үнэ нэмэгдэж, ТЭМ-н үнэ өсөж байгаатай холбоотой үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалаад бид аль болох санхүүгийнхаа үзүүлэлтийг эерэг үзүүлэлтийн ямар түвшинд хүргэж ажиллах вэ гэдэг төсөөллийг урьдчилсан байдлаар гаргасан. Зардлын хувьд хамгийн бага түвшинд байхаар төлөвлөөд байна. энэ тухай ТУЗ-ийн хурал дээр танилцуулсан. Нөхцөл байдлаас шалтгаалан тухайн үедээ тодотгол хийгээд явъя гэдэг шийдэлд хүрээд байна.

**Хурлын дарга 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт**

Хурлын танилцуулга хурлын материалд дэлгэрэнгүй байгаа. 2025 онд манай компанийн хувьд ихээхэн хэмжээний худалдан авалт хийлээ. Компанийн ашиг 74,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан хэдий ч маш их засвар үйлчилгээ хийсэн. Энэ жил Төлөөлөн Удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын багийн хамтын ажиллагаа, ажлын хамт олны мэрийлт, чармайлт

байсан гэж дүгнэж байна. компани 2025 онд 6,3 тэрбумын борлуулалт хийж төлөвлөгөөний биелэлт 96,7%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Үйл ажиллагааны тухайд бол ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс нийт 10 удаа хуралдсан. Энэхүү хурлаар гүйцэтгэх удирдлагын багт чиглэл өгөх заавар зөвлөгөө, хамтран ажиллах, бололцоог хангах, санхүүгийн чиглэлээр хамтран ажилласан.

**Хурлын дарга:** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулга

ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах нэр дэвшигч нар дэвшиж байгаа

Д.Бат-Эрдэнэ, Б.Бат-Өлзий, Б.Одонцэцэг, С.Оюунчимэг, Ц.Дамбажанцан, Л.Цээсүрэн

Хараат бус ТУЗ-ийн гишүүдэд

Э.Шинэбаяр, Л.Баянмөнх, Б.Эрдэнэцэцэг

Шинээр нэр дэвшиж байгаа Л.Баянмөнх Цахиур ХХК-н хөдөө орон нутаг хариуцсан дарга, туршлагатай менежер гэдгээр нь та бүхэн мэдэж байгаа байх. Б.Эрдэнэцэцэг Цахиур ХХК-ийн ахлах нягтлан бодогч

Дээрх нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг хувьцаа эзэмшигч та бүхэн танилцуулье. Эдгээр нэр дэвшигчдээс сонгох саналаа өгөхдөө та бүхэн тооллогын комиссын зааврын дагуу саналын хуудсаа бөглөөрэй.

**Хурлын дарга:** ТУЗ-аас гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах.

Энэ жил компани 74,5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. НӨАТ, Нийгмийн даатгалд маш их өртэй байгааг үндэслэн тараахгүй байхаар шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчид маань олон жил ашиг авч байгаагүй. За 10 минутын хугацаанд асуулт хариулт явуулья.

**Хувьцаа эзэмшигч:** надаа 2 асуудал байна.

1. Яагаад маркетинг борлуулалтын албаны цалингийн зардал өссөн бэ
2. Жор орцын дагуу ТЭМ-аа хэрэглэж байгаа юу

**Хариулт: Ерөнхий нягтлан бодогч** гүйцэтгэх захирлын тушаалаар борлуулалтын албаны худалдааны төлөөлөгч жолооч нарт урамшуулал нэмэгдэл олгосон учир цалин өгсөн.

**Ерөнхий технологич:** энэ жил тариа ургац муу байсан учир гурилын чанар муу, ус даах чадваргүй өнгө өгөхгүй гэх зэрэг шалтгаанаар зарим гурилын хэрэглэхгүй байх тохиолдол байгаа.

Өөр асуулт байхгүй тул тооллогын комиссын тооллогын танилцуулах, хурлоор гарах шийдвэрийг танилцуулах, хурало хаах гэсэн ажил үлдлээ.

Тооллогын комисс:

**“ДАРХАН ХҮНС” ХК-НИЙ**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

“Дархан Хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

“Дархан Хүнс” ХК-ийн саналын эрхтэй 617718 ширхэг хувьцаанаас 71,6% буюу 442679 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч оролцсон.

**Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 71,6% буюу 442679 ширхэг хувьцааны 7 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

| зөвшөөрсөн |      | татгалзсан |      | түдгэлзсэн |      |
|------------|------|------------|------|------------|------|
| тоо        | хувь | тоо        | хувь | тоо        | хувь |
| 442679     | 100% | 0          | 0%   | 0          | 0%   |

2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 71,6% буюу 442679 ширхэг хувьцаатай 7 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 87% зөвшөөрсөн, 13% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

| зөвшөөрсөн |      | татгалзсан |      | түдгэлзсэн |      |
|------------|------|------------|------|------------|------|
| тоо        | хувь | тоо        | хувь | тоо        | хувь |
| 382499     | 87%  | 60180      | 13%  | 0          | 0%   |

3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 71,6% буюу 442679 ширхэг хувьцаатай 7 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

| зөвшөөрсөн |      | татгалзсан |      | түдгэлзсэн |      |
|------------|------|------------|------|------------|------|
| тоо        | хувь | тоо        | хувь | тоо        | хувь |
| 442679     | 100% | 0          | 0%   | 0          | 0%   |

**Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 71,6% буюу 442679 ширхэг хувьцаатай 7 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн санал:

| д/д | ТУЗ-ийн ердийн гишүүний нэр | Саналын хувь | кумулятив аргаар өгсөн саналыг тоо |
|-----|-----------------------------|--------------|------------------------------------|
|-----|-----------------------------|--------------|------------------------------------|

|   |                        |      |        |
|---|------------------------|------|--------|
| 1 | Дашгай БАТ-ЭРДЭНЭ      | 100% | 442679 |
| 2 | Сэржээ ОЮУНЧИМЭГ       | 100% | 442679 |
| 3 | Бат-Эрдэнэ БАТ-ӨЛЗИЙ   | 100% | 442679 |
| 4 | Бат-Эрдэнэ ОДОНЦЭЦЭГ   | 100% | 442679 |
| 5 | Цэрэндоной ДАМБАЖАНЦАН | 100% | 442679 |
| 6 | Лхагва ЦЭЭСҮРЭН        | 100% | 442679 |

Хараат бус гишүүдэд

| д/д | ТУЗ-ийн хараат бус<br>гишүүний нэр | Саналын хувь | кумулятив<br>аргаар өгсөн<br>саналыг тоо |
|-----|------------------------------------|--------------|------------------------------------------|
| 1   | Эрдэнэбаатар ШИНЭБАЯР              | 100%         | 442679                                   |
| 2   | Лхаасүрэн БАЯНМӨНХ                 | 100%         | 442679                                   |
| 3   | Буянхүү ЭРДЭНЭЦЭЦЭГ                | 100%         | 442679                                   |

Тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

**Хурлын дарга:** Хувьцаа эзэмшигчийн хурлаар санал хураалт амжилттай явагдаж дууслаа. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээ ажлын амжилт хүсч, компанийг үр ашигтай хамтран ажиллах болсонтой талархаж байна. Бүгдэнд амжилт хүсье. За тогтоол уншиж танилцуулье. 2026 онд ногдол ашиг хуваарилах болтугай гэж хүсэн ерөөе. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдье.

Хурлын дарга

Н.Ичинхорлоо

Тэмдэглэл хөтөлсөн

Д.Мөнхцэцэг